



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.6 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны Газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор батлахыг аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

2.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого" дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3.Хянаж зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт тус бүрийг албажуулж, баталж мөрдүүлэх, нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (Ж.Эрдэнэбат)-нд даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

23000049

Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн  
27 дугаар тогтоолын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон  
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

..... аймгийн Боловсрол,  
шинжлэх ухааны газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны газрын  
дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-4

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, зорилтот хөтөлбөрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргад бодлогын зөвлөгөө, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлж, мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд агентлагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Засаг даргын өмнө тайлагнана.



Албан тушаалын зорилт:

1. Боловсрол, шинжлэх ухааны болон холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох;
2. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсролын сургалтын болон шинжлэх ухааны байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөн туслах;
3. Боловсролын чанар, хүртээмж, хүүхдийн хөгжил, хамгаалал, шинжлэх ухаан, технологийг орон нутагт хөгжүүлэх талаар нийгмийн түншлэлийг хөгжүүлэх;
4. Салбарын хяналтын бодлого, төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх, улсын ахлах байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих;
5. Байгууллагыг захиргааны болон хүний нөөцийн удирдлага, манлайллаар хангах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах, хяналт тавих, хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Улс, орон нутгийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, зорилтот хөтөлбөрт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах;	Бодлогын баримт бичигт тусгагдсан салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Г,Х
	2. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, салбарын сайдын тушаал, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тайлагнах, мэдээллээр хангах;	Хууль тогтоомж, шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна.	Г,Х
	3. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх орон нутгийн бодлого, төлөвлөгөө, нийтлэг зохицуулалтын асуудлаар аймгийн Засаг дарга болон Засаг даргын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн орон нутаг дахь салбар зөвлөл шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг	Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, цаг хугацаанд нь тайлагнасан байна.	Т,Г,Х





	зохион байгуулах, үр дүн, гүйцэтгэлийг тайлагнах;		
	4.Сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээ, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, хүний нөөцийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээний бодлогын хэрэгжилтийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;	Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх бодлогын хэрэгжилтийг хангасан байна.	Г,Х,Ш
	5.Тэгш хамран сургах боловсрол, насан туршдаа суралцахуй, сургалтын байгууллагын засаглал, менежмент, боловсролын салбарын цахим шилжилт, цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй хамаарах хууль тогтоомж, шийдвэр, арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, талуудын оролцоог хангах, үр дүнг тооцох, тайлагнах;	Суралцагчийн сурч боловсрох эрх, хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангасан байна.	Г,Х,Ш
	6.Сургууль, дотуур байрын орчны аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, шаардлага, норм, нормативыг мөрдүүлэх ажлыг орон нутагт нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах.	Сургалтын орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авсан байна.	Г,Х,Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, үр дүнг тайлагнах;	Хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд хамран сургалтын хувь өссөн байна.	Т, Г,Х,Ш
	2. Сургалтын чанарыг сайжруулах, сургалтад технологи ашиглах, зайн болон цахим хэлбэрээр сургалт зохион байгуулах чиглэлээр багш, ажилтанд мэргэжил, арга зүйн	Сургалтын чанарт эерэг өөрчлөлт гарсан байна.	Т,Г,Х,Ш





	дэмжлэг үзүүлэх ажлыг удирдан чиглүүлэх, хамтран ажиллах;		
	3. Багш, ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдамж, зохицуулалтаар хангах ажлыг зохион байгуулах, үр дүнг тооцох;	Багш, ажилтны мэргэжлийн хөгжилд ахиц гарсан байна.	Т,Г,Х,Ш
	4. Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, сургуульд суурилсан менежментийг хөгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;	Үйлчилгээний чанарт ахиц гарсан байна.	Т,Х,Ш
	5. Цахим хичээлийн сан бүрдүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулахад багш, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг чиглүүлэн удирдах;	Цахим хичээлийн сан бүрдсэн байна.	Т,Г,Х,Ш
	6. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах суралцахуйн түгээмэл загвар бүхий орчин бүрдүүлэх, тэдний хөгжлийг дэмжихэд багш, ажилтан, сургалтын байгууллагад зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдалт нэмэгдсэн байна.	Т,Г,Х,Ш
	7. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах чиглэлээр сургалтын байгууллагад зөвлөн туслах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;	Сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээ тодорхой болсон байна.	Т,Г,Х,Ш
	8. Сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн эзэмшүүлэх болон иргэдийн насан туршдаа суралцахуйг дэмжих, дунд, ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг нэгдсэн зохицуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих;	Мэргэжил, арга зүйн удирдлагаар хангасан байна.	Т,Г,Х,Ш





	9. Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, үр дүнг тайлагнах.	Хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлсэн байна.	Г,Ш
3 дугаар зорилтын хүрээнд	1. Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын асуудлаар нийгмийн түншлэлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааны сүлжээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Хүүхдийн хөгжил, хамгааллын нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны сүлжээ бий болсон байна.	Г,Х,Ш
	2. Орон нутагт сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор хөгжүүлэхэд орон нутгийн ажил олгогч, аж ахуй нэгж, байгууллагыг холбох, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас боловсролын чанар, сургалтын орчныг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал санаачилгыг дэмжих, түншлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;	Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх таатай орчин бүрдсэн байна.	Г,Ш
	3. Аймаг, орон нутагт шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа боловсруулалтын ажилд орон нутгийн харьяат эрдэмтэд, судлаачид болон мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, түншлэлийг бэхжүүлэх;	Шинжлэх ухаан, технологи, инновацийг орон нутагт хөгжүүлэх нийгмийн түншлэл, хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.	Г,Ш
	4. Шинжлэх ухааны ололт, амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах ажлыг орон нутагт зохион байгуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;	Түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлыг тогтмолжуулсан байна.	Г,Х,Ш
	5. Орон нутаг дахь мэргэжлийн болон дээд боловсролын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд ажил олгогчийг татан оролцуулах, хамтран ажиллах;	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь нэмэгдсэн байна.	Г,Х,Ш





	6. Орон нутгийн онцлог тохирсон цэцэрлэг, сургууль, дотуур байрын хүнсний хангамжийн тогтолцоог бүрдүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн салбар холбоодтой хамтран ажиллах.	Сургалтын байгууллагын онцлогт тохирсон, аюулгүй, шим тэжээллэг хоол хүнсний хангамжийн тогтолцоо нэвтэрсэн байна.	Г,Х,Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт, стандарт, техникийн зохицуулалтын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх ажлыг холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулах;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х,Ш
	2. Хяналт, шалгалтын үйл ажиллагаанд шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх;	Хяналт шалгалтын үр дүн сайжирсан байна.	Г,Х,Ш
	3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгуулах арга хэмжээг холбогдох хуульд заасны дагуу авч хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах, улсын байцаагчийн өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих.	Эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан байна.	Г,Х, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Т,Г,Х
	2. Албан хэрэг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангасан байна.	Г,Х,Ш
	3. Боловсрол, шинжлэх ухааны асуудлаар аймгийн Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	Мэргэшлийн удирдлагаар хангасан байна.	Т,Г





	4. Холбогдох яам, нутгийн захиргааны байгууллагаас шаардсан эрхлэх асуудалд хамаарах мэдээ, мэдээлэл, судалгааг шуурхай, чанартай гаргаж өгөх ажлыг зохион байгуулах;	Мэдээ, мэдээллийг бодитой, үнэн зөв гаргасан байна.	Г,Х,Ш
	5. Байгууллагын соёл төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх;	Байгууллагын соёл төлөвшүүлэх болон албан хаагчдыг мэргэшүүлэх арга хэмжээ авсан байна.	Г,Х,Ш
	6. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;	Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.	Г,Ш
	7. Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг маягтын дагуу мэдээлэх ажлын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;	Мэдээ, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв гаргасан байна.	Х,Ш
	8. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэл, үр дүнг орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцна.	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна	Г,Х,Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>-Боловсрол /011/;</li> <li>-Сэтгэл судлал /0313/;</li> <li>-Математик /05401, 054102 /;</li> <li>-Эдийн засаг/031101;</li> <li>-Эрх зүй/ 042101/;</li> <li>-Менежмент ба удирдахуй /041304,041305/;</li> <li>-Программ хангамж /061302/.</li> </ul>	
Мэргэшил	-Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	
Туршлага	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах;</li> <li>- нэгжийн албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой, хуваарилах, адил тэгш хандах;</li> </ul>





		<ul style="list-style-type: none"> <li>- нэгжийн үйл ажиллагаан дахь эрсдэлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, авах арга хэмжээний төслийг боловсруулах, танилцуулах;</li> <li>- албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих;</li> <li>- албан хаагчдын сургалт хөгжлийн асуудалд идэвхтэй дэмжлэг үзүүлж, тасралтгүй суралцагч байгууллага болох соёлыг төлөвшүүлэх;</li> <li>- саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- гүйцэтгэлийг цаг тухайд нь үнэлдэг байх;</li> <li>- бусад.</li> </ul>
	<p>Дүн шинжилгээ хийх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- аливаа асуудлын талаар бүрэн ойлголт авахын тулд шаардлагатай мэдээллийг цуглуулах, үнэлэх, тайлбарлах;</li> <li>- хоорондоо шууд хамааралгүй нөхцөл байдлын байж болох уялдаа холбоог тодорхойлдог байх;</li> <li>- болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөдөг байх;</li> <li>- мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон системийн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа хийх;</li> <li>- судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлого боловсруулах;</li> <li>- судалгааны үр дүн, шийдлийн хувилбарын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулах;</li> <li>- бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах;</li> <li>- бусад.</li> </ul>
	<p>Асуудал шийдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- хуульд нийцсэн, оновчтой үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;</li> <li>- аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль, тогтоомжийн төсөлд санал өгөх;</li> <li>- гарсан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэрлэх;</li> <li>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний зэрэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;</li> </ul>





		<ul style="list-style-type: none"> <li>- аливаа шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг тусгадаг байх;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих чиглүүлэх зэргээр үлгэрлэх;</li> <li>- нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, дэвшилтэт арга барил, үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч сэтгэлгээ, хандлагыг дэмжих;</li> <li>- байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;</li> <li>- гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа хамт олны саналыг тусгах, үр дүнд чиглүүлэх</li> <li>- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;</li> <li>- нээлттэй, шударга байх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан мэдээллийг түгээх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийг дэвшилтэт технологи, ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх;</li> <li>- албан ажил чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн Засаг дарга

Засаг даргын Тамгын газрын дарга


Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Ахлах арга зүйч –

Бусад харилцах субъект :

-Боловсрол, шинжлэх ухааны яам, эрхлэх асуудалд хамаарах хэрэгжүүлэгч агентлаг, хүрээлэн, төв;

-Аймгийн Засаг даргын орлогч;





Арга зүйч - Төрийн үйлчилгээний албан хаагч - Нийт-	-Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албаны дарга, мэргэжилтнүүд; -Сумдын Засаг дарга; -Төрийн болон төрийн бус байгууллага; -Иргэн, хуулийн этгээд.
---	--

### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)  20... оны ... дугаар сарын ...-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 23 0201  <u>Дугаар:</u> 027

### Албан тушаалын тодорхойлолтыг баталсан

<u>Байгууллагын нэр:</u> АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: ..... Дугаар: ..... (тамга/тэмдэг) АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр
--

